

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ДЭРГЭДЭХ ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№

2023 оны 05 сарын 17

Налайх дүүрэг

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2023 оны 05 сарын 17-ны өдрийн 15:00 цагт эхлэж, 15:30 минутад дуусгав.

Хуралд: Зөвлөлийн дарга
Нарийн бичгийн дарга
Гишүүд:

Н.Пүрэвсүрэн
Э.Энгүүн
Б.Батбилэг
Г.Ганцэцэг нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Засвар үйлчилгээтэй холбоотойгоор

СОНССОН НЬ: Н.Пүрэвсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хавар болж байгаатай холбогдуулаад, байгууллагын гадна өнгө төрхийг сайжруулах, урсгал засвар хийхтэй холбоотойгоор өнөөдөр хуралдах гэж байна. Хийх шаардлагатай ямар ажлууд байна, төсөв мөнгө нь яаж шийдэгдэхээр байна, энэ талаар ярилцая.

Б.Батбилэг: Эхний ээлжинд байшингийнхаа гадна өнгийг сэргээх, хашаа хайсаа будах, мөн дээврийн усны хаялага дээрээс бараг унаж ирэхээр болсныг засварлах ажлууд байна. Мөн худгийн хашааны онгорхойг нөхөж, хаалгыг бөхлөх хэрэгтэй

Г.Ганцэцэг: Мөн бохирын хоолойн халдаг утсыг нэг солих шаардлагатай байгаа. Хавар болгон бохир хөлддөгөөс болж байгууллагын хэвийн ажиллагаанд нөлөөлж байна.

Н.Пүрэвсүрэн: Гадна засвараа өөрсдөө хийх боломж байгаа юу? Эсвэл гаднаас мэргэжлийн хүн хөлслөх хэрэгтэй юу? Жишээлбэл, дээврийн усны хаялагыг засварлахад том шатнаас эхлээд шаардлагатай хэрэгсэл юу байна?

Б.Батбилэг: Аль болох дотоод нөөц бололцоогоороо хийе гэж бодож байна. Шаардлагатай тоног хэрэгсэлийг Налайх Политехникийн Коллеж зэргээс асууя. Түрээслэх үү, зээлэх үү, аль боломжоороо шийдвэрлэе.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: 1. Шаардлагатай завсар үйлчилгээний нэр, шаардагдах төсвийг гаргаж, худалдан авалтыг хийх ажлыг Ахлах нягтлан Г.Ганцэцэгт

2. Засвар үйлчилгээг байгууллагын дотоод нөөц бололцоонд тааруулан хийж гүйцэтгэх ажлыг Инженер Б.Батбилэг нарт тус тус үүрэг болгов.

ХЯНАСАН:
КОМИССЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ПҮРЭВСҮРЭН
Э.ЭНГҮҮН